БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ш.ЕЛ

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙЖ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар: ХЕТ-26/04

1.	Боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" - Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт; - Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын 4.7.2г, 4.7.3 4.7.5 б, 5.1.3 дахь заалтууд; - Дорнод аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зорилтын 1.4.6 дахь хэсэг. - Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /2019 оны хөгжлийн төлөвлөгөөнд тодотгол хийх/ - Төлөвлөлтийн дунд хугацаа 2019-2025, хэтийн төлөв 2025-2030
2.	Баримт бичгийн үе шат	**Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө** Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үе шатны дараалаар хийнэ. Үүнд: а.Хот байгуулалтын суурь судалгаа; - Байр зүйн дэвсгэр зураг /М1:2000/ - Инженер геологийн судалгаа /Гүйцэтгэгч нь ажлын даалгаврыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай зөвшилцөнө./ - Нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа болон бусад судалгаа/-г 2025 оны байдлаар хийх; б. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, судалгаа, шинжилгээний үр дүнд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцийг тодорхойлох; в. Төлөвлөлтийн үндсэн шийдэл, боловсруулалт; г. Ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвийг хөгжүүлэх арга хэмжээний эхний 5 жилийн төлөвлөгөө, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд санал болгох төсөл хөтөлбөр
		- Халхгол сум нь Улаанбаатар хотоос 1000 км, Дорнод аймгийн төвөөс зүүн урд зүгт 360 км зайд оршдог. Засаг захиргааны Цогтсүмбэр, Ялалт, Ташгай гэсэн 3 багтай, , Тус сум нь баруун талаараа Матад сумтай, хойд талаараа

Scanned with CamScanner

3.	Байршил, эдийн засаг нийгмийн хөгжлийн байдал	Матад сумтай, хойд талаараа БНХАУ-ын Хөлөнбуйр аймаг, зүүн талаараа БНХАУ-ын Хянган аймаг, өмнөд талаараа БНХАУ-ын Шилийн гол аймгуудтай хиллэдэг. Баянхошуу-Өвдөг, Сүмбэр-Рашаант гэсэн хилийн хоёр боомттой. - 2026 оны 01 дүгээр сарын 01-ны байдлаар сумын нутаг дэвсгэр 2,809,299 га талбай буюу 28092,99 км². Үүнээс: бэлчээрийн газар 1371793 га, хадлангийн талбай 353765 га, тариаланд тохиромжтой газрын хэмжээ 45878 га, "Ташгайн таван нуур" байгалийн нөөц газар 93565.3 га, дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан 587.0 мян/га, тосгон ба суурин газар 4670,87 үүнээс барилгажсан талбай 144,69 га, гэр хорооллын эзлэх талбай 221,05 нийтийн эзэмшлийн талбай 4217,59 зам талбай, шугам сүлжээ 1768.3 га, Дулааны өгөх буцах шугам 1480 метр, бохирын төв магистрал шугам 1254 метр газар тус тус эзэлж байна. 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар сумын хэмжээнд 984 өрхийн 3257 суурин хүн ам буюу түр оршин суугчтай нийлээд 4000 орчим хүн амьдарч байна. Сумын төв Цогтсүмбэр багт нийт хүн амын 50.3 хувь буюу 1641 иргэн төвлөрсөн байдлаар амьдарч байна. - Сумын төв нь дулаан хангамжийн нэгдсэн халаалтад холбогдсон, цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээ, ариун цэврийн цэвэрлэх байгууламжтай. - Нэгдсэн уурын зуухны халаалтад одоогийн байдлаар төсвийн 8 байгууллага, 240 айл өрх, 6 аж ахуйн нэгж хамрагдаад байна. Хоёр байгууллага холбогдоогүй байна. - Сумын төвд Засаг даргын Тамгын газар, 300 хүний суудалтай Соёлын төв, 20 ортой Эрүүл мэндийн төв, 650 хүүхдийн багтаамжтай 3 байгууламжаас бүрдэх ЕБС-ийн комплекс барилга. Үүнд 180 хүүхдийн дотуур байр, Урлагийн заал Үдийн цайны заал, Спорт заал, хичээлийн барилга, 150 хүүхдийн 6 бүлэгтэй хүүхдийн Цэцэрлэг, ХЦ-ийн 0198-р анги, ЗХ-ний 329-р тусгай салбар, ГТУА-62-р анги, Цагдаагийн тасаг, Ялалт музей, НДЦГ-ын хамгаалалтын захиргаа, ШТСтанц хоёр, Дашваанжил ГАЗ, ХААН, Төрийн банк, ТАХ-ийн байр, "Халхгол нэгдэл" ОНӨААТҮГазар, 1975 онд ашиглалтад орсон 17 орон сууц, Газар тариалангийн 10 аж ахуйн нэгж, 9 хоршоо, зэрэг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ, интернэтийн шилэн кабельд холбогдсон. Үүрэн холбооны Жи-мобайл, Юнител, Мобиком, зэрэг гар утас болон суурин утасны сүлжээтэй. - ХАА: 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 89934 толгой малтай. Үүнээс: адуу 27880, тэмээ 195, үхэр 27599, хонь 20674, ямаа 13586 байна.

Scanned with CamScanner

4.	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)	Төлөвлөлт хийх газрын хэмжээ: Сумын төв, Ялалт баг, Буйр тосгоны газарт нарийвчилсан тодотгол хийх **/Төлөвлөлтийн үе шатанд талбайг нарийвчлан сонгох, суурьшлын бүс, өмчлөлийн га газрыг нэмэгдүүлэхээр төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөнө.**
5.	Баримт бичгийн бүрдэл, шийдвэрлэх үндсэн асуудал	**Хот төлөвлөлтийн суурь судалгаа:** "Хот байгуулалтын тухай" хуулийн 12.9 дэх хэсэг болон холбогдох хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийн дагуу /инженер-геологи, байр зүйн зураглал, газар нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгааны тайлан г.м/ боловсруулна. **Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө: 2019-2025, 2025-2035 он** **Архитектур орон зайн төлөвлөлтийн зураглал:** - Бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал, байршлын тойм зураг; - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний зураг ; **/М1:2000/** - Ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг; **/М1:2000/** - Нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэлийн зураг; ❖ Газар ашиглалтын үндсэн бүсчлэл **/М1:2000/** ❖ Газар ашиглалтын дэд бүсчлэл **/М1:2000/** ❖ Суурьшлын нутаг дэвсгэр **/М1:2000/** ❖ Үйлдвэрлэлийн нутаг дэвсгэр **/М1:2000/** ❖ Ландшафт-амралтын нутаг дэвсгэр **/М1:2000/** ❖ Хот орчмын нутаг дэвсгэр **/М1:2000/** Эдгээрийн хязгаар, түүнд мөрдөх дэглэмийг тодорхойлох - Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн зураг; **Газар зохион байгуулалт: /М1:2000/** - Газар зохион байгуулалт ; - Эхний ээлжийн төлөвлөлт ; **Зам, тээврийн сүлжээ: /М1:2000/** - Гудамж, замын сүлжээ; - Явган замын сүлжээ; - Нийтийн тээврийн сүлжээ; - Дугуйн замын сүлжээ; - Төмөр замын сүлжээ; - Авто замын ус зайлуулах сувгийн сүлжээ; - Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт; - Өндержилт төлөвлөлт; **Инженерийн дэд бүтцийн хангамж: /М1:2000/** - Инженерийн хангамжийн эх үүсвэрүүд, шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндержилт, улаан шугам; - Дулаан хангамж; Одоо ашиглаж байгаа дулаан хангамж нь орон сууц, албан байгууллагууд, аж ахуйн нэгжийг хэвийн халааж чадахгүй доголдол удаа дараа үүсэж, халаалтын системийн схем, шугам холболтуудыг стандартын дагуу шаардлага хангасан, эх үүсвэрийг сайжруулах уурын зуухны хүчин чадлыг тооцож нэмэгдүүлэхээр

Scanned with CamScanner

		төлөвлөлтөд тусгах - Цахилгаан хангамж; Одоо байгаа гэр хорооллуудыг дахин төлөвлөлтөд оруулж цахилгаан эрчим хүчний шугам болон дэд станцуудыг өргөтгөл хийхээр төлөвлөх - Усан хангамж; Гэр хорооллуудын га газрыг нэмэгдүүлэхээр төлөвлөж ундны 4-5 усан сан байгуулж, чанарын шаардлага хангасан орчин үеийн цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулахыг төлөвлөлтөд тусгах - Ариутгах татуурга; Одоо ашиглаж байгаа барилга байгууламж болон нийтийн эзэмшлийн цэвэр бохир усны хаалт, аваарын худгуудыг 10-15 нэмэгдүүлэхээр төлөвлөх мөн төлөвлөлтөд тусгагдах барилгуудыг ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг сайжруулах сүүлийн үеийн дэвшилтэт технологийн дагуу төлөвлөх - Холбоо мэдээлэл; Хуучин гэр хорооллын болон шинээр төлөвлөлтөд оруулж барилга байгууламжийг орчин үеийн харилцаа холбооны дэд бүтэцтэй байхаар төлөвлөх /Шилэн кабель дотор, гадна/ - Сэргээгдэх эрчим хүч; - Хийн хангамж /шаардлагатай тохиолдолд/ **Цэцэрлэгжилт, ногоон байгууламж:/М1:2000/** **Сумын төв, Ялалт багт цэцэрлэгт хүрээлэн, Буйр нуурын элсний нүүдлээс хамгаалах ойн төгөл, байгуулахаар төлөвлөх** - Цэцэрлэгт хүрээлэн, парк; - Тохижилт, ногоон байгууламж; - Гол, нуур, усан толио, цөөрмийн төлөвлөлт; **Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт /М1:2000/** - Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, худалдаа, үйлчилгээ; - Архитектур, түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийн хамгаалалт, төлөвлөлт; **Гамшгийн менежментийн төлөвлөлт:/М1:5000 /** - Гал унтраах автомашиныг усаар цэнэглэх гадаргын ус хуримтлуулах нуур, цөөрөм, гудамж замын гидрант; - Түр хоргодох байр, цуглах талбай, дуут дохио; - Нүүлгэн шилжүүлэх, авран хамгаалах; **Аялал жуулчлалын төлөвлөлт: /М1:2000/** - Рашаан сувилал; - Амралт; - Аялал жуулчлалын маршрут; **Хог хаягдлын төлөвлөлт, зохион байгуулалт; /М1:5000/** **Буйр нуурын амралтын газруудын эко нойл, ариун цэврийн байгууламжийг орчин үеийн дэвшилтэд технологитой байхаар төлөвлөх.** **Газар ашиглалтын нэгж талбарт хуваасан төлөвлөгөө; /М1:2000/** **Тайлбар бичиг:** - Ерөнхий төлөвлөгөө боловсруулсан үндэслэл, зорилго, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, аргачлал, арга зүй, ажлын төлөвлөгөө, хуваарь;

Scanned with CamScanner

		- Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо болон өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн үнэлэлт, дүгнэлт; - Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл; - Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг гаргах, ээлж дараалыг төлөвлөлтийн үе шатны дагуу тогтоох, хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийн тооцоог хийх г.м/; - Эхний ээлжид хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах; - Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт; - Хүрээлэн буй орчин болон түүх, соёл, уран барилгын дурсгалыг хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг нарийвчлан гаргаж, төлөвлөлтийн холбогдох зураг, зургийн даалгавар зэрэг материалыг хавсаргана. - Тайлбар бичиг, хөрөнгө оруулалтын тооцоо; **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө:** - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг; Товч танилцуулга: - Хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат /сонголтоор/ - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хураангуй; - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй; - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал; - Олон нийтэд зориулсан тараах материал /брошюр, анимэшн/; **Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:** **1.Бичиглэлийн баримт бичиг** - Судалгааны баримт бичиг /*.pdf, *.jpg/; - Байр зүйн баримт бичиг /*.pdf, *.dwg/; - Инженер-геологийн судалгаа /*.pdf, *.dwg/; - Тайлбар бичиг /*.pdf, *.jpg/; - Батлагдсан баримт бичиг сканер /Тогтоол, Захирамж, шийдвэр, хурлын тэмдэглэл, иргэдийн санал г.м/, /*.pdf, *.jpg/; **2.Зураглалын баримт бичиг** - Ажлын файл /*.dwg, *.shp, *.skp, lumion, *.max, *.cdr/; - Батлагдсан баримт бичиг сканер /*.jpg, *.pdf/; **3.Товч танилцуулга** - Олон нийтийн хэлэлцүүлэг, хурлын танилцуулга /*.ppt/; Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эхлэлийн, дундын, эцсийн тайлангийн хугацаанд бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А1 форматаар 1% захиалагчид, улсын экспертизийн дүгнэлт гарч, эрх бүхий байгууллагаар батлагдсан хот

Scanned with CamScanner

		байгуулалтын баримт бичгийг орон нутгийн архивд эх хувиар 1%, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус бүр хуулбар 1% үйлдэж цаасан хэлбэрээр хүлээлгэн өгнө. Хот байгуулалтын баримт бичгийг тоон байдлаар DVD дээр бичиж хүлээлгэж өгөх: **Үүнд:** - Байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааны тайлан /*.pdf, зураглал *.dwg/; - Ерөнхий төлөвлөгөөний файл /*.dwg, *.shp/; - Зураглалын материал /*.jpeg/; - Тайлбар бичиг /*.pdf/; - Холбогдох хурлын тэмдэглэл, шийдвэр сканердсан /*doc, *pdf;/ - Зөвшөөрөлцсөн байгууллагын шийдвэр сканердсан /*pdf/; - Улсын экспертизийн дүгнэлт сканердсан /*pdf/; - Батлагдсан шийдвэр сканердсан /*pdf/ тус тус хуулж 3 хувь бэлтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, тухайн орон нутгийн аймгийн Архив, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт тус бүр хүлээлгэж өгнө. - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д нэвтрэх эрх авч баримт бичгийг төслийн шатанд оруулан холбогдох байгууллагаас цахимаар санал авах, батлагдсаны дараа эцсийн байдлаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээллийг цахим системд оруулна. **Тайлбар:** Ажлын зургийг гүйцэтгэхдээ "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах" журмыг баримтална. - Батлагдсан ажлын даалгаварт тусгагдсан иж бүрэн зураг төслийн эх хувь, тайлбар бичгийн хамт хэвлэмэл болон тоон байдлаар CD-нд 4 хувь үйлдэж Дорнод аймгийн архив, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Архив мэдээллийн төв, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Халхгол сумын Засаг даргын тамгын газарт тус бүр хүлээлгэн өгөх.
6.	Баримт бичиг боловсруулах хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 4 сар /120 хоног/ **Эхлэлийн тайлан:** /30 хоног/ - Одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглал /ажлын даалгаврыг зураг төсөл зохиогч, захиалагч байгууллагуудтай хамтран боловсруулах, дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийг мэдээллийн санд бүртгүүлэн акт үйлдэж баталгаажуулсан байх/, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, судалгааны түвшинд харьцуулсан хувилбар дэвшүүлж төлөвлөлтийн тооцоолол боловсруулах; - Олон нийтээс санал авах /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санал авах/

Scanned with CamScanner

		Дундын тайлан: /60 хоног/ - Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх; - Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/ - Инженер-геологийн судалгаа /ажлын даалгаврыг зураг төсөл зохиогч, захиалагч байгууллагуудтай хамтран боловсруулах, инженер-геологийн дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэн магадлалаар баталгаажуулах/-ны ажлыг дууссан байх. **Эцсийн тайлан:** /30 хоног/ Ерөнхий төлөвлөгөөнд мэргэжлийн байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх. Магадлалаар хянагдах хугацаанд энд тооцоогүй тул гэрээний тусгай нөхцөлд заана.
7.	Баримт бичиг боловсруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хот, байгуулалтын хуулийн 15.1.2 дахь заалтын дагуу төслийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. 2026 оны сумын орон нутгийн хөгжлийн сан Төсөв: 50.0 сая төгрөг.
8.	Захиалагч байгууллага	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Халхгол сумын Засаг даргын тамгын газар;
9.	Гүйцэтгэгч байгууллага	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй Аж ахуй нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлнэ;
10.	Зөвшөөрөлцөх байгууллага	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор болон Халхгол сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай зөвшөөрөлцөх; - Архитектур, хот байгуулалтын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх; - Онцгой байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага; - Инженерийн дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэхдээ шугам сүлжээний газруудтай зөвшөөрөлцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх; - Зураг төсөлд магадлал хийлгэж, магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах. - Аймаг, сумын Засаг дарга; - Онцгой байдлын газар; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар - Орон нутгийн инженерийн хангамжийн хангагч байгууллагууд;
11.	Онцгой нөхцөл	-Нутаг дэвсгэрийн бүсчлэл, дэд бүсүүдэд мөрдөх давхар талбайн харьцаа (FAR), барилга бүрхцийн харьцаа (BCR)-ны шийдлийг тусгах -Тухайн орон нутгийн байгаль цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, тохижилт бүхий орон зайн бүтэцтэй хот төлөвлөлтийн онцлог шийдлийг гаргах;

Scanned with CamScanner

		- Авто замын сүлжээ, нийтийн үйлчилгээг боловсронгуй хүртээмжтэй болгох; - Чойбалсан хот болон бусад хот суурин газруудтай холбогдох зам тээврийн сүлжээ мастер төлөвлөгөөтэй уялдуулан зам тээврийн сүлжээг төлөвлөх. - Орон сууцны хорооллыг цогцолбороор нь шийдвэрлэх; - Одоогийн байдлаар гэр хорооллууд эгнээ, гудамж төлөвлөлт байхгүй тул дахин төлөвлөлт хийх шаардлагатай мөн шинээр хороолол үүсэж өмчлөлийн газар олголт хийгдэхгүй байгаа тул газар зохион байгуулалтад тодотгол хийж га талбайг нэмэгдүүлэхээр төлөвлөгөөнд тусгах**, га талбайн хэмжих боломжгүй байгаа тул судалгааны явцад мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөх зөвшилцөж тогтоох** - Эдлэн газартай амины орон сууц төлөвлөх, - Ялалт багийн төв, Буйр тосгон нь суурин амьдралтай эрчим хүч цахилгаанд холбогдсон дэд бүтэцтэй тул цаашид барилга байгууламж, гэр хорооллыг нэмэгдүүлэх, өмчлөлийн газар олгож тэлэх шаардлага хэрэгцээ байгаа тул суурьшлын бүс тогтоох, газрыг нэмэгдүүлж дахин төлөвлөлтөд оруулахаар тусгах. / **Мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөж га газрыг нэмэгдүүлнэ.** - Нийгэм, эдийн засаг, байгалийн баялаг, хот байгуулалтын иж бүрэн төлөвлөгөө, тооцоо судалгааны үндсэн дээр хотжилтыг дэмжих бүс болон хот орчмын бүсийн хязгаар, дэглэмийг тогтоох; - Ундны болон ахуйн хэрэгцээний усны асуудлыг нарийвчлан судлах, шийдлийг гаргах; - Инженер-геологийн нөхцөлөөс хамааруулан инженерийн бэлтгэл арга хэмжээ болон байгалийн аюултай үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг арга хэмжээг төлөвлөх буюу эрсдэл өндөртэй газарт цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай зэрэг барилгажилт багатай бүс төлөвлөх; - Төлөвлөлтийн шийдэл, нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, газар зохион байгуулалт, дахин төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор, хотын нийгэм эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, байгаль орчин, хөрөнгө оруулалтын асуудлыг сумын Засаг даргын тамгын газартай зөвшилцөх; - Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын уялдааг хангаж урьд үүссэн зөрчлийг арилгаж инженерийн шугам сүлжээг гэр хорооло́лд байгуулах бэлтгэл арга хэмжээг төлөвлөх; - Зураг төсөлд тодорхой эшлэл авсан техникийн баримт бичгийг тодорхой заах, холбогдох тооцоо, судалгааг тайлбар бичигт нарийвчлан тусгах; - Ерөнхий төлөвлөгөөний зураглалыг “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг” MNS 6736:2018 стандартыг баримтлан зураглаж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах; - ЗТБХБСайдын 2012.06.13-ны №183 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий төлөвлөгөөний төсөлд олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ын дагуу суманд

Scanned with CamScanner

		хэлэлцүүлэг хийх /Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулах/, иргэд, байгууллагуудын саналыг төлөөлөгч томилон 7-с доошгүй хоног авах, төлөвлөлтийн санал авах. - Төлөвлөлтийн шийдлийг сумын болон аймгийн Засаг дарга, ИТХ, мэргэжлийн байгууллагатай зөвшилцөх; - Ерөнхий төлөвлөгөөг мөрдөх, хэрэгжүүлэх талаар орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулах. - "Хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г "Хот байгуулалтын тухай хууль"-ийн 12.6, 12.7-р заалтуудыг үндэслэн сумын ЗДТГ-тай хамтран боловсруулж, ерөнхий төлөвлөгөөтэй хамт аймгийн ИТХ-аар батлуулна.

Зөвшилцсөн:

Бүс, Орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг

Аймгийн ерөнхий архитекторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Урансүх

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Гүенбат

Хянасан

Халхгол сумын Засаг дарга Э.Бямбажаргал

Боловсруулсан:

Халхгол сумын Засаг даргын орлогч Д.Эрдэнэдэлгэр

Scanned with CamScanner